**НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зорчигч тээвэр нэг ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: НТАГ-2025/97/НА-СТА-ОНӨҮГ**

Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга: Ч.Болд
Утас: 7000-7734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn

Санхүү-Нийцлийн аудитын хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр
Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер Я.Алтанцэцэг
Утас: 325093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn
Ахлах аудитор: Ё.Лхагвадулам
Утас: 325093 Цахим хаяг: lkhagvadulamyo@audit.gov.mn
Аудитор: Б.Цолмон
Утас: 325093 Цахим хаяг: tsolmonba@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn
Улаанбаатар хот
2025 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025.03.14 № 01/332

танай ____________-ны № ____________-т

ЗОРЧИГЧ ТЭЭВЭР НЭГ
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА
Б.ХУЯГБААТАР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Зорчигч тээвэр нэг ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тус байгууллагын хот доторх болон хот орчимд зорчих “Зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл”-ийг авто тээврийн үндэсний төв ТӨҮГ-аас таван жилээр баталгаажуулсан байна.

**Аудитын гол асуудал**

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2024 оны 28 дугаар тогтоолоор Зорчигч тээвэр нэг ОНӨААТҮГ байгуулагдаж 2024 оны 6 дугаар сараас үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 47 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 95.4 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ЭРДЭНЭЖАРГАЛ

C:\Users\zendmene.d\Desktop\2025\Word\Yvaan bichig\2025.03.15 Zorchigch teever 1.docx

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

---

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Мөрийн дугаар | Балансын зүйл | Үлдэгдэл | |
|---|---|---|---|
| | | 1 сарын 1 | 12 сарын 31 |
| 1.1.01 | Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө | 1,250,000,000.00 | 1,053,723,885.96 |
| 1.1.02 | Дансны авлага | 248,925,555.44 | 46,949,387.05 |
| 1.1.03 | Татвар, НДШ-ийн авлага | 4,640,170.39 | 0.00 |
| 1.1.04 | Бусад авлага | 128,713,768.60 | 139,062,449.09 |
| 1.1.06 | Бараа материал | 1,212,968,631.64 | 1,596,646,618.42 |
| 1.1.11 | Эргэлтийн хөрөнгийн дүн | 2,845,248,126.07 | 2,836,382,340.52 |
| 1.2.01 | Үндсэн хөрөнгө | 54,427,618,271.69 | 53,838,015,280.79 |
| 1.2.02 | Биет бус хөрөнгө | 5,513,600,000.00 | 5,513,600,000.00 |
| 1.2.10 | Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 59,941,218,271.69 | 59,351,615,280.79 |
| 1.3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 62,786,466,397.76 | 62,187,997,621.31 |
| 2.1.1.01 | Дансны өглөг | 0.00 | 1,357,017,501.53 |
| 2.1.1.02 | Ажилтан албан хаагчдад өгөх өглөг | 1,134,329,668.51 | 7,035,785.20 |
| 2.1.1.03 | Татварын өр | 171,463,499.76 | 0.00 |
| 2.1.1.10 | Бусад богино хугацаат өр төлбөр | 503,929,363.64 | 10,636,594.88 |
| 2.1.1.13 | Богино хугацаат өр төлбөрийн дүн | 1,809,722,531.91 | 1,374,689,881.61 |
| 2.1.2.04 | Бусад урт хугацаат өр төлбөр | 21,672,524,074.82 | 19,783,771,032.82 |
| 2.1.2.06 | Урт хугацаат өр төлбөрийн дүн | 21,672,524,074.82 | 19,783,771,032.82 |
| 2.2 | Өр төлбөрийн нийт дүн | 23,482,246,606.73 | 21,158,460,914.43 |
| 2.3.01 | Өмч: - төрийн | 39,304,219,791.03 | 39,304,219,791.03 |
| 2.3.08 | Эздийн өмчийн бусад хэсэг | 0.00 | 1,949,645,830.93 |
| 2.3.09 | Хуримтлагдсан ашиг | 0.00 | -224,328,915.08 |
| 2.3.09.1 | Тайлангийн үеийн ашиг | 0.00 | -224,328,915.08 |
| 2.3.11 | Эздийн өмчийн дүн | 39,304,219,791.03 | 41,029,536,706.88 |
| 2.4 | ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН | 62,786,466,397.76 | 62,187,997,621.31 |

### 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Мөрийн дугаар | Балансын зүйл | Өмнөх оны дүн | Тайлант жилийн дүн |
|---|---|---|---|
| 01 | Борлуулалтын орлого (цэвэр) | 0.00 | 21,150,459,783.00 |
| 02 | Борлуулалтын өртөг | 0.00 | 15,698,991,421.51 |
| 03 | Нийт ашиг( алдагдал) | 0.00 | 5,451,468,361.49 |
| 04 | Түрээсийн орлого | 0.00 | 946,000.00 |
| 05 | Хүүний орлого | 0.00 | 417,065.97 |
| 05.1 | Бусад ашиг ( алдагдал) | 0.00 | 0.00 |
| 06 | Ногдол ашгийн орлого | 0.00 | 0.00 |
| 07 | Эрхийн шимтгэлийн орлого | 0.00 | 0.00 |
| 08 | Бусад орлого | 0.00 | 53,930,642.63 |
| 08.1 | Орлогын дүн | 0.00 | 55,293,708.60 |
| 09 | Борлуулалт, маркетингийн зардал | 0.00 | 0.00 |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 0.00 | 5,490,561,697.47 |
| 11 | Санхүүгийн зардал | 0.00 | 0.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 12 | Бусад зардал | 0.00 | 240,529,287.70 |
| 12.1 | Зардлын дүн | 0.00 | 5,731,090,985.17 |
| 13 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | 0.00 | 0.00 |
| 14 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | 0.00 | 0.00 |
| 15 | Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | 0.00 | 0.00 |
| 16 | Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз) | 0.00 | 0.00 |
| 17.1 | Олз, гарзын дүн | 0.00 | 0.00 |
| 18 | Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал) | 0.00 | -224,328,915.08 |
| 19 | Орлогын татварын зардал | 0.00 | 0.00 |
| 20 | Татварын дараах ашиг (алдагдал) | 0.00 | -224,328,915.08 |
| 21 | Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал) | 0.00 | 0.00 |
| 22 | Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал) | 0.00 | -224,328,915.08 |
| 23 | Бусад дэлгэрэнгүй орлого | 0.00 | 0.00 |
| 23.1 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү | 0.00 | 0.00 |
| 23.2 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 0.00 | 0.00 |
| 23.3 | Бусад олз (гарз) | 0.00 | 0.00 |
| 24 | Орлогын нийт дүн | 0.00 | 0.00 |
| 25 | Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал) | 0.00 | 0.00 |

**2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

*2024 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон* *\/төгрөгөөр/*

| № | Үзүүлэлт | Өмч | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 01 | 2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 02 | НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө,алдааны залруулга | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 04 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 05 | Бусад дэлгэрэнгүй орлого | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 06 | Өмчид гарсан өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 07 | Зарласан ногдол ашиг | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 08 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 09 | 2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл | 39,304,219,791.03 | 0.00 | 0.00 | 39,304,219,791.03 |
| 10 | НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө,алдааны залруулга | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 11 | Залруулсан үлдэгдэл | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 12 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | 0.00 | 0.00 | -224,328,915.08 | -224,328,915.08 |
| 13 | Бусад дэлгэрэнгүй орлого | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 14 | Өмчид гарсан өөрчлөлт | 0.00 | 1,949,645,830.93 | 0.00 | 1,949,645,830.93 |
| 15 | Зарласан ногдол ашиг | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 16 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 17 | 2024 оны 12 сарын 31-р үлдэгдэл | 39,304,219,791.03 | 1,949,645,830.93 | -224,328,915.08 | 41,029,536,706.88 |

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

*2024 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 0 | Мөнгөн хөрөнгөөс мөнгөн хөрөнгө рүү бичсэн гүйлгээ | 0.00 | 0.00 |
| 1 | Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | 0.00 | 0.00 |
| 1.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 0.00 | 19,347,653,358.44 |
| 1.1.1 | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 0.00 | 140,000.00 |
| 1.1.2 | Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого | 0.00 | 0.00 |
| 1.1.3 | Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | 0.00 | 117,436,207.99 |
| 1.1.4 | Буцаан авсан албан татвар | 0.00 | 0.00 |
| 1.1.5 | Татаас, санхүүжилтийн орлого | 0.00 | 19,194,799,177.56 |
| 1.1.6 | Бусад мөнгөн орлого | 0.00 | 35,277,972.89 |
| 1.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 0.00 | 19,517,784,151.85 |
| 1.2.1 | Ажиллагчдад төлсөн | 0.00 | 9,300,636,212.37 |
| 1.2.2 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 0.00 | 3,001,629,052.71 |
| 1.2.3 | Бараа материал худалдан авахад төлсөн | 0.00 | 341,124,034.23 |
| 1.2.4 | Ашиглалтын зардалд төлсөн | 0.00 | 98,640,390.84 |
| 1.2.5 | Түлш шатахуун, тээврийн хөлс,сэлбэг хэрэгсэлд төлсөн | 0.00 | 5,044,438,964.22 |
| 1.2.6 | Хүүний төлбөрт төлсөн | 0.00 | 0.00 |
| 1.2.7 | Татварын байгууллагад төлсөн | 0.00 | 1,045,050,882.64 |
| 1.2.8 | Даатгалын төлбөрт төлсөн | 0.00 | 230,055,145.97 |
| 1.2.9 | Бусад мөнгөн зарлага | 0.00 | 456,209,468.87 |
| 1.3 | Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 0.00 | -170,130,793.41 |
| 2 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | 0.00 | 0.00 |
| 2.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 0.00 | 73,499,535.97 |
| 2.1.1 | Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | 0.00 | 0.00 |
| 2.1.2 | Биет бус хөрөнгө борлуулсны орлого | 0.00 | 0.00 |
| 2.1.3 | Хөрөнгө оруулалт борлуулсны орлого | 0.00 | 0.00 |
| 2.1.4 | Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого | 0.00 | 0.00 |
| 2.1.5 | Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт | 0.00 | 0.00 |
| 2.1.6 | Хүлээн авсан хүүний орлого | 0.00 | 417,065.97 |
| 2.1.7 | Хүлээн авсан ногдол ашиг | 0.00 | 0.00 |
| 2.1.8 | Бусад | 0.00 | 73,082,470.00 |
| 2.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 0.00 | 99,639,530.96 |
| 2.2.1 | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 0.00 | 99,603,150.00 |
| 2.2.2 | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 0.00 | 0.00 |
| 2.2.3 | Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн | 0.00 | 0.00 |
| 2.2.4 | Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 0.00 | 0.00 |
| 2.2.5 | Бусдад олгосон зээл болон урьдчилгаа | 0.00 | 0.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2.2.6 | Бусад | 0.00 | 36,380.96 |
| 2.3 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 0.00 | -26,139,994.99 |
| 3 | Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | 0.00 | 0.00 |
| 3.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 0.00 | 1,753,072,500.00 |
| 3.1.1 | Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 0.00 | 1,753,072,500.00 |
| 3.1.2 | Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 0.00 | 0.00 |
| 3.1.3 | Төрөл бүрийн хандив | 0.00 | 0.00 |
| 3.1.4 | Бусад | 0.00 | 0.00 |
| 3.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 0.00 | 1,753,077,825.64 |
| 3.2.1 | Зээл,өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | 0.00 | 1,753,072,500.00 |
| 3.2.2 | Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн | 0.00 | 0.00 |
| 3.2.3 | Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн | 0.00 | 0.00 |
| 3.2.4 | Төлсөн ногдол ашиг | 0.00 | 0.00 |
| 3.2.5 | Бусад | 0.00 | 5,325.64 |
| 3.3 | Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 0.00 | -5,325.64 |
| 4 | Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | 0.00 | -196,276,114.04 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 1,250,000,000.00 | 1,250,000,000.00 |
| 6 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 1,250,000,000.00 | 1,053,723,885.96 |

### 2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

*2024 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон* *\/мянган төгрөгөөр/*

| Д/д | Эдийн засгийн үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Дүн | Хувь |
| 1 | **1. Нийт орлого** | **33,152,954,550.00** | **21,205,753,491.60** | **11,947,201,058.40** | **64** |
| 2 | Шугамын үйлчилгээний орлого | 2,583,142,380.00 | 2,381,898,900.00 | 201,243,480.00 | 92 |
| 3 | Санхүүжилтын орлого | 28,570,142,750.00 | 16,873,591,750.00 | 11,696,551,000.00 | 59 |
| 4 | Нөхөн олговор - ХБИ | 281,121,910.00 | 213,777,500.00 | 67,344,410.00 | 76 |
| 5 | Нөхөн олговор - ӨН | 1,383,636,780.00 | 1,544,696,900.00 | -161,060,120.00 | 112 |
| 6 | Нөхөн олговор - Цэрэг, цагдаа | 108,318,730.00 | 56,408,900.00 | 51,909,830.00 | 52 |
| 7 | Үйл ажиллагааны бусад орлого | 226,592,000.00 | 135,379,541.60 | 91,212,458.40 | 60 |
| 8 | **2. Нийт зардал** | **35,443,661,700.00** | **21,430,082,406.68** | **14,013,579,293.32** | **60** |
| 9 | **Цалин** | **16,005,983,230.00** | **11,570,644,545.08** | **4,435,338,684.92** | **72** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 10 | Цалин | 13,087,677,300.00 | 9,585,615,050.00 | 3,502,062,250.00 | 73 |
| 11 | Хоол унааны хөнгөлөлтийн зардал | 1,146,816,000.00 | 633,318,395.08 | 513,497,604.92 | 55 |
| 12 | ндш | 1,771,489,930.00 | 1,351,711,100.00 | 419,778,830.00 | 76 |
| 13 | **Шатахуун** | **11,560,108,640.00** | **5,385,026,100.00** | **6,175,082,540.00** | **47** |
| 14 | Шатахуун | 11,288,908,640.00 | 5,217,026,100.00 | 6,071,882,540.00 | 46 |
| 15 | Цэнхэр түлш | 271,200,000.00 | 168,000,000.00 | 103,200,000.00 | 62 |
| 16 | Тосолгооны материал | 483,304,740.00 | 230,034,560.00 | 253,270,180.00 | 48 |
| 17 | Сэлбэг хэрэгсэл | 1,280,955,170.00 | 206,504,540.00 | 1,074,450,630.00 | 16 |
| 18 | Дугуйн зардал | 424,000,000.00 | 97,816,500.00 | 326,183,500.00 | 23 |
| 19 | Засварын матөриал үйлчилгээ | 232,278,240.00 | 128,203,605.08 | 104,074,634.92 | 55 |
| 20 | Хөдөлмөр хамгаалал/Хамгаалах, норм хувцас/ | 594,388,000.00 | 39,495,680.00 | 554,892,320.00 | 7 |
| 21 | Бусад үйлчилгээ | 576,151,620.00 | 129,961,760.00 | 446,189,860.00 | 23 |
| 22 | Даатгалын үйлчилгээ | 428,701,620.00 | 298,650,500.00 | 130,051,120.00 | 70 |
| 23 | Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ | 147,450,000.00 | 223,983,090.00 | -76,533,090.00 | 152 |
| 24 | Ариун цэврийн зардал /Эм бэлдмэл/ | 82,791,110.00 | 20,016,930.00 | 62,774,180.00 | 24 |
| 25 | Бичиг хэрэглэл | 49,300,000.00 | 30,363,180.00 | 18,936,820.00 | 62 |
| 26 | Програм хангамж | - | | 0.00 | 0 |
| 27 | Үндсэн хөрөнгийн элэгдэл | 2,980,900,840.00 | 2,653,065,370.00 | 327,835,470.00 | 89 |
| 28 | Тавилга эд хогшил /ХО/ | - | - | 0.00 | 0 |
| 29 | Компьютер тоног төхөөсөмж /ХО/ | - | - | 0.00 | 0 |
| 30 | **Ашиглалтын зардал** | **334,614,860.00** | **98,630,676.52** | **235,984,183.48** | **29** |
| 31 | Цахилгаан | 197,911,510.00 | 49,490,970.00 | 148,420,540.00 | 25 |
| 32 | Ус | 16,578,920.00 | 5,572,130.00 | 11,006,790.00 | 34 |
| 33 | Халаалт дулаан | 120,124,440.00 | 31,026,416.52 | 89,098,023.48 | 26 |
| 34 | Цэвэр бохир ус | - | 12,541,160.00 | -12,541,160.00 | 0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 35 | Хог | - | - | 0.00 | 0 |
| 36 | Харилцаа холбоо | 56,944,370.00 | 11,753,310.00 | 45,191,060.00 | 21 |
| 37 | Үндсэн хөрөнгийн татвар | 84,543,420.00 | - | 84,543,420.00 | 0 |
| 38 | Газрын төлбөр | 12,107,960.00 | - | 12,107,960.00 | 0 |
| 39 | Тээврийн хэрэгслийн татвар | 49,558,410.00 | 10,407,350.00 | 39,151,060.00 | 21 |
| 40 | Албан томилолт | - | - | 0.00 | 0 |
| 41 | Сургалт сурталчилгаа | 30,000,000.00 | 4,034,850.00 | 25,965,150.00 | 13 |
| 42 | Хүлс-эн авалт баяр ёслол | - | 3,500,000.00 | -3,500,000.00 | 0 |
| 43 | Тэтгэвэр тэтгэмж, шагнал | 300,000,000.00 | 35,832,210.00 | 264,167,790.00 | 12 |
| 44 | Шимтгэлийн зардал | 255,731,100.00 | 236,065,280.00 | 19,665,820.00 | 92 |
| 45 | Үйл ажиллагааны бусад | 50,000,000.00 | 12,066,370.00 | 37,933,630.00 | 24 |
| 46 | Үйл ажиллагааны бус бусад | - | 4,026,000.00 | -4,026,000.00 | 0 |
| 47 | Өмнөх оны үлдэгдэл | - | - | 0.00 | 0 |
| 48 | 3. Ашиг /алдагдал/ | (2,290,707,150.00) | (224,328,915.08) | -2,066,378,234.92 | 10 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 297,865.0 мянган төгрөгийн зөрчил [1] илэрснээс 1,000.0 мянган төгрөгийн төлбөрийн 1 акт тогтоож, 293,365.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 3,500.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 297,865.0 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 28,086.2 мянган төгрөгөөр бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Төсвийн тухай хуульд заасан хугацаанд санхүүгийн тайлан мэдээг ирүүлээгүй байна. | | | | | | | 1 | - | | | | |
| Анхан шатны баримтгүй 1,000.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байна. | 1 | 1,000.0 | 1 | 1,000.0 | | | | | | | | |
| Тайлант онд 327,919.7 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.. | 1 | 127.919.7 | | | 1 | 127.919.7 | | | | | | |
| Тайлант онд 165,445.3 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна. | 1 | 165,445.3. | | | 1 | 165,445.3. | | | | | | |
| Ёслолын үйл ажиллагааны 3,500.0 мянган төгрөгийн зардал нь ажлын тайлангүй, холбогдох анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна | 1 | 3,500.0 | | | | | 1 | 3,500.0 | | | | |
| | 3 | **297,865.0** | **1** | **1,000.0** | 1 | 293,365.0 | **2** | **3,500.0** | | | | |

### 4.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зорчигч тээвэр нэг

ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | |
| Албан хэрэгцээнд 91,648.6 төгрөгийн бараа материал, хөрөнгийг цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, нэр бүхий 6 аж ахуйн нэгжээс худалдан авсан байна. | 1 | - | - | - | 1 | 91,648.6 |
| **Дүн** | | | | | | **91,648.6** |